



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

.....аймгийн
Мал эмнэлгийн газар

Нэгжийн нэр:

Сумын мал эмнэлгийн тасаг

Албан тушаалын нэр:

Улсын байцаагч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл ТЗ-6

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

.....аймгийн
.....сумын.....баг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн:

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй:

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Сумын нутаг дэвсгэрт салбарын бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, мал эмнэлгийн ажил, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангуулах, мал, амьтны өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэл, хорио цээрийн дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавих, мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний аюулгүй байдлын ажлыг зохион байгуулж хэрэгжилтийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт

- 1.Сумын нутаг дэвсгэрт салбарын бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих.
- 2.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, гэрээт малын эмчийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах.
- 3.Мал, амьтны өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний технологи, хорио цээрийн арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих.
- 4.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх.
5. Бусад чиг үүрэг.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах -Т, Хариуцан гүйцэтгэх -Г, Хянах -Х, Шийдвэрлэ-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Сумын нутаг дэвсгэрт хууль тогтоомж мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах талаар төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилтийг нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагатай хамтран болон дангаар зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.	Г
	2.Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль тогтоомж зөрчсөн шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгохыг шаардах, эсхүл дээд шатны байгууллагад гомдол гаргаж шийдвэрлүүлэх,		Г
	3.Малчин, мал, амьтныг өмчлөгч этгээдэд мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх, албадан сахиулахдаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хүндэтгэн ажиллах;		Г
	4.Үйл ажиллагааны чиглэлээр мэдээллийн		Г



	нэгдсэн сан бүрдүүлэх;		
2 дугаар зорилтын хүрээнд	1. Мал эмнэлгийн ажил үйлчилгээ эрхлэгчид мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актийн хэрэгжилтийг хангуулах, албадан сахиулахдаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хүндэтгэн ажиллах;	Мал эмнэлгийн ажил үйлчилгээнд хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.	
	2. Хууль тогтоомж, технологийн зөрчил гаргасан, бусдад хохирол учруулсан аж ахуйн нэгж, малын эмчийн лиценз, зөвшөөрөл, мал амьтны эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхийг хүчингүй болгуулах, үйл ажиллагааг түр болон бүр мөсөн зогсоох саналаа тухайн эрх олгосон байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;		Г
	3. Мал эмнэлгийн ажил үйлчилгээг эрхлэх талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, зөрчлийн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх;		Г
3 дугаар зорилтын хүрээнд	1. Мал, амьтны халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх арга хэмжээний технологи, үйл ажиллагаанд байнгын хяналт тавих;	Мал, амьтны өвчинтэй тэмцэх, эрүүлжүүлэх талаарх өмчийн эзний хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	2. Мал, амьтны халдварт өвчин гарсан үед хэрэгжүүлэх хорио цээрийн арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;		Г
	3. Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний шилжилт хөдөлгөөнд хяналт тавих;		Г
	4. Мал, амьтны эм, бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн хэрэглээ, чанар, аюулгүй байдалд хяналт тавих;		Г
	5. Сумын нутаг дэвсгэрт илэрсэн гоц халдварт, халдварт өвчний тохиолдолдтой тэмцсэн арга хэмжээний үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгч, эрсдэлийн үнэлгээ хийх;		Г
	6. Хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлнэ;		Г



4 дүгээр зорилтын хүрээнд	1.Хуулиар харьяалуулсан зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тогтоосон хугацаанд прокурорын хяналтанд холбогдох ажиллагааг явуулах;	Зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа хуулийн хүрээнд явагдана.	Г
	2.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн баримт бичгүүдийг холбогдох журмын дагуу хууль зүйн үндэслэлтэй бүрдүүлж, оролцогчийн эрх үүргийг хангаж ажиллах;		Г
	3.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэлийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй, зөрчлийн үр дагаврыг арилгах, зардлыг нөхөн төлөхтэй холбоотой шийдвэрийг биелүүлээгүй бол албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд хүсэлт гаргах, шаардлагатай бол шүүх хуралд оролцож нотлох;		Г
	4.Эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг эс зөвшөөрч холбогдогчийн гаргасан гомдол, эсхүл хүчингүй болгох, өөрчлүүлэхээр прокурорын гаргасан дүгнэлтийн дагуу шүүхээс хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, тайлбар хүргүүлэх, нотлох;		Г
5 дугаар зорилтын хүрээнд	1.Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан биелэлт, хэрэгжилтийг тайлагнаж ажиллах, өөрийгөө болон бусад албан хаагчийг авлигад өртөхөөс урьдчилан сэргийлэх, хөрөнгө, орлогын мэдүүлгээ хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргаж өгөх;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж дүгнэсэн байна.	Г
	2.Эрхэлсэн ажлын чиглэлээр нутгийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтанг мэдээллээр хангаж, хамтран ажиллах;	Төрийн үйлчилгээг чанартай, түргэн хүргэж ажилласан байна.	Г
	3.Байгууллагын дотоод дүрэм, журам, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдлөг болгон ажиллах, төрийн захиргааны манлайллыг хэрэгжүүлэх;	Эмх цэгц ажлын зохион байгуулалт сайжирсан	Г



		байна.	
	4.Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллах.	Шинэ санааг ажлын арга барилдаа хэрэглэсэн байна	Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй;
Мэргэжил	Малын их эмч, мал эмнэл зүй;
Мэргэшил	Төрийн албаны богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд, эсхүл мэргэжлээрээ ажилласан байх
Ур чадвар	<p>Дүн шинжилгээ хийх</p> <p>-мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх;</p> <p>-судалгааны үр дүн, шийдлийн хувилбаруудыг харьцуулан үнэлж, санал боловсруулах, танилцуулах;</p> <p>-бусад;</p>
	<p>Асуудал шийдвэрлэх</p> <p>-албан үүргээ хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх;</p> <p>-хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах;</p> <p>-тулгамдсан асуудлыг шийдвэрлэх саналыг боловсруулж, удирдлагад танилцуулах;</p> <p>-аливаа асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх;</p> <p>-бусад;</p>
	<p>Манлайлах</p> <p>-ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч байдлаар бусдыг үлгэрлэх;</p> <p>-үйл ажиллагаандаа шинэлэг санааг нэвтрүүлэх, бусдын шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг дэмжих;</p> <p>-хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг манлайлах;</p> <p>-албаны үйл ажиллагааны шинэлэг үзэл санааг нэгжийн хамт олонд тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх;</p>
	<p>Бусад</p> <p>-англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;</p> <p>-багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусад таниулах;</p> <p>-орчин үеийн арга хэлбэрийг ашиглан мэдээллийг хүргэх;</p>



		-албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; -компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах;
--	--	--

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

-Мал эмнэлгийн газрын дарга /улсын ахлах байцаагч/

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

- Аймгийн мал эмнэлэгийн газрын албаны дарга, байцаагч, мэргэжилтнүүд
- Орон нутгийн удирдлагууд болон төрийн байгууллагын холбогдох албан тушаалтан
- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага
- Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
..... З.Батсүлд

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2019 оны 09 дугаар сарын 10 ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 19 10 02

Дугаар: 87

VI. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:

Байгууллагын нэр:

.....АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР

Шийдвэрийн огноо:

Дугаар:.....

(тамга/тэмдэг)

ДАРГА...../ /

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

